



МОНГОЛЫН  
ХӨРӨНГИЙН  
БИРЖ

# 2019 Э-сонин

76-р дугаар

11-Р САР






# ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

## Зах зээлийн тойм


/2019.11.30-ны өдрийн байдлаар/

|                                            |                |
|--------------------------------------------|----------------|
| 1. Арилжаа явагдсан өдөр                   | 19             |
| 2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/       | 19,973,577,275 |
| Хувьцаа /анхдагч/                          | 0              |
| Хувьцаа /хоёрдогч/                         | 19,891,150,815 |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/        | 82,426,460     |
| Компанийн бонд /анхдагч/                   | 0              |
| Компанийн бонд /хоёрдогч/                  | 0              |
| 3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг | 11,839,242     |
| Хувьцаа /анхдагч/                          | 0              |
| Хувьцаа /хоёрдогч/                         | 11,838,425     |
| Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/        | 817            |
| Компанийн бонд /анхдагч/                   | 0              |
| Компанийн бонд /хоёрдогч/                  | 0              |
| 4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо              | 4,386          |


## Зах зээлийн үнэлгээ




## TOP-20 индекс



## MSE A индекс



## MSE B индекс



## Бүртгэлтэй хувьцаат компани

|                          |     |
|--------------------------|-----|
| 1. Нийт компанийн тоо    | 198 |
| 100% төрийн өмчит        | 18  |
| Төрийн өмчийн оролцоотой | 10  |
| Хувийн өмчийн            | 170 |
| I ангилал                | 14  |
| II ангилал               | 44  |
| III ангилал              | 140 |

## Гишүүн үнэт цаасны компани

|                                     |    |
|-------------------------------------|----|
| 1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо | 57 |
| Үүнээс:                             |    |
| Брокер, Дилер                       | 51 |
| Андеррайтер                         | 19 |
| Хөрөнгө оруулалтын зөвлөх           | 13 |



## Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2019.11.30-ны байдлаар/

| №  | Нэр                          | Үнэт цаас авсан |                | Үнэт цаас зарсан |                | Арилжааны дүн /авсан, зарсан/ (₮) |
|----|------------------------------|-----------------|----------------|------------------|----------------|-----------------------------------|
|    |                              | Тоо ширхэг      | Үнийн дүн (₮)  | Тоо ширхэг       | Үнийн дүн (₮)  |                                   |
| 1  | Ти Ди Би Капитал             | 2,203,539       | 17,509,381,738 | 1,350,587        | 12,305,340,734 | 29,814,722,472                    |
| 2  | Ард капитал групп            | 148,430         | 15,184,725     | 1,260,700        | 4,132,293,362  | 4,147,478,087                     |
| 3  | Ард секюритиз                | 3,722,726       | 814,435,243    | 2,148,986        | 554,775,410    | 1,369,210,653                     |
| 4  | Инвескор капитал             | 15,174          | 31,163,033     | 589,038          | 1,207,294,564  | 1,238,457,597                     |
| 5  | БиДиСек                      | 1,987,447       | 568,752,241    | 2,305,531        | 442,332,651    | 1,011,084,892                     |
| 6  | Голомт Капитал               | 1,083,643       | 258,779,800    | 744,503          | 352,385,922    | 611,165,721                       |
| 7  | Гаули                        | 67,148          | 193,846,493    | 249,206          | 217,027,453    | 410,873,947                       |
| 8  | Бумбат-Алтай                 | 609,956         | 172,994,931    | 660,482          | 193,335,641    | 366,330,571                       |
| 9  | Стандарт инвестмент          | 645,930         | 82,791,153     | 1,252,320        | 153,534,614    | 236,325,767                       |
| 10 | Централ секьюритийз          | 11,555          | 1,941,500      | 5,010            | 4,350,200      | 171,144,620                       |
| 11 | Апекс Капитал                | 172,042         | 38,623,353     | 182,722          | 69,607,955     | 108,231,308                       |
| 12 | Новел инвестмент             | 43,379          | 33,482,976     | 318,443          | 55,828,899     | 89,311,875                        |
| 13 | Лайфтайм инвестмент          | 92,653          | 52,747,518     | 29,550           | 4,065,054      | 56,812,572                        |
| 14 | Тулгат чандмань баян         | 8,713           | 4,260,012      | 139,841          | 43,144,281     | 47,404,293                        |
| 15 | Мирэ Эссет Секьюритис Монгол | 341,881         | 18,394,745     | 160,794          | 14,499,063     | 32,893,807                        |
| 16 | Сикап                        | 439,351         | 29,505,261     | 0                | 0              | 29,505,261                        |
| 17 | Домикс сек                   | 4,254           | 1,023,730      | 59,383           | 27,584,405     | 28,608,135                        |
| 18 | Блүмсбюри секюритиес         | 164,368         | 19,635,965     | 52,156           | 5,550,373      | 25,186,337                        |
| 19 | Хүннү Эмпайр                 | 11,439          | 8,954,640      | 28,663           | 13,364,097     | 22,318,737                        |
| 20 | Тэнгэр капитал               | 8,119           | 3,600,634      | 39,893           | 17,984,244     | 21,584,878                        |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2019.11.30-ны байдлаар/

| №  | Симбол | Үнэт цаасны нэр       | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /₮/  | Дээд Ханш | Доод Ханш | Өөрчлөлт /%/ |
|----|--------|-----------------------|--------------------|----------------|-----------|-----------|--------------|
| 1  | MIK    | Мик холдинг           | 1,251,758          | 16,236,870,190 | 12,230    | 11,000    | 11.18        |
| 2  | INV    | Инвескор ББСБ         | 606,098            | 1,242,325,201  | 2,196     | 1,966     | 4.93         |
| 3  | AARD   | Ард санхүүгийн нэгдэл | 325,497            | 551,881,162    | 1,780     | 1,485     | 13.19        |
| 4  | ADB    | Ард кредит ББСБ       | 3,601,348          | 285,641,638    | 81        | 75        | 0.44         |
| 5  | MNDL   | Мандал даатгал        | 57,009             | 282,499,707    | 5,350     | 4,750     | 6.78         |
| 6  | APU    | Апу                   | 361,635            | 192,970,444    | 579       | 500       | 14.69        |
| 7  | BDL    | Могойн гол            | 20,250             | 182,250,000    | 9,000     | 9,000     | 0.00         |
| 8  | TTL    | Таван толгой          | 17,106             | 111,000,675    | 6,690     | 6,310     | 2.36         |
| 9  | SUU    | Сүү                   | 561,727            | 110,709,621    | 216       | 181       | 11.36        |
| 10 | AIC    | Ард даатгал           | 151,641            | 109,933,566    | 763       | 676       | 1.55         |
| 11 | GOV    | Говь                  | 361,699            | 94,700,339     | 270       | 250       | -6.32        |
| 12 | MFC    | Монос хүнс            | 1,111,395          | 74,497,384     | 70        | 64.7      | 3.54         |
| 13 | TUM    | Түмэн шувуут          | 392,162            | 57,603,142     | 156       | 140       | 6.90         |
| 14 | UYN    | Монгол савхи          | 76,730             | 49,874,500     | 650       | 650       | 8.33         |
| 15 | LEND   | Лэндмн ББСБ           | 1,125,663          | 49,111,707     | 48.5      | 38.03     | 3.92         |
| 16 | BDS    | Би ди сек             | 49,722             | 42,274,190     | 948       | 850       | 11.53        |
| 17 | UID    | Улсын их дэлгүүр      | 27,658             | 35,481,829     | 1,490     | 1,000     | -11.92       |
| 18 | RMC    | Ремикон               | 1,130,315          | 33,702,816     | 33        | 26        | 4.00         |
| 19 | MBW    | Монгол базальт        | 93,323             | 23,777,663     | 270       | 242       | -1.70        |
| 20 | HRM    | Гермес центр          | 158,020            | 18,995,438     | 138       | 120       | 7.20         |



## Ханшийн өсөлттэй хувьцаа

/2019.11.30-ны байдлаар/

| №  | Үнэт цаас нэр                | Арилжигдсан<br>/Ширхэг/ | Хаалтын ханш |            | Ханшийн<br>өөрчлөлт /₮/ | Өөрчлөлт<br>/%/ |
|----|------------------------------|-------------------------|--------------|------------|-------------------------|-----------------|
|    |                              |                         | 2019-10-31   | 2019-11-30 |                         |                 |
| 1  | ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП          | 735                     | 175.00       | 264.00     | 89.00                   | 50.86           |
| 2  | ХАЙ БИ ОЙЛ                   | 34,776                  | 51.00        | 64.00      | 13.00                   | 25.49           |
| 3  | ХӨХ ГАН                      | 9,000                   | 72.00        | 87.00      | 15.00                   | 20.83           |
| 4  | МОНГОЛЫН ЦАХИЛГААН<br>ХОЛБОО | 539                     | 381.50       | 450.00     | 68.50                   | 17.96           |
| 5  | ХОРГО ХАЙРХАН                | 174                     | 60.00        | 70.00      | 10.00                   | 16.67           |
| 6  | МОННООС                      | 530                     | 1,700.00     | 1,955.00   | 255.00                  | 15.00           |
| 7  | БЭРХ УУЛ                     | 3                       | 600.00       | 690.00     | 90.00                   | 15.00           |
| 8  | ИХ БАРИЛГА                   | 27                      | 2,999.00     | 3,448.00   | 449.00                  | 14.97           |
| 9  | АПУ                          | 361,635                 | 503.11       | 577.01     | 73.90                   | 14.69           |
| 10 | АТАР-ӨРГӨӨ                   | 6                       | 53,000.00    | 60,300.00  | 7,300.00                | 13.77           |
| 11 | ХАСУ-МАНДАЛ                  | 30                      | 5,690.00     | 6,450.00   | 760.00                  | 13.36           |
| 12 | МАТЕРИАЛИМПЕКС               | 210                     | 6,000.00     | 6,800.00   | 800.00                  | 13.33           |
| 13 | АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ        | 325,497                 | 1,524.00     | 1,725.00   | 201.00                  | 13.19           |
| 14 | БИ ДИ СЕК                    | 49,722                  | 850.00       | 948.00     | 98.00                   | 11.53           |
| 15 | СҮҮ                          | 561,727                 | 180.14       | 200.61     | 20.47                   | 11.36           |
| 16 | МИК ХОЛДИНГ                  | 1,251,758               | 11,000.00    | 12,230.00  | 1,230.00                | 11.18           |
| 17 | МОНГОЛ САВХИ                 | 76,730                  | 600.00       | 650.00     | 50.00                   | 8.33            |
| 18 | АДУУН ЧУЛУУН                 | 310                     | 1,340.00     | 1,440.00   | 100.00                  | 7.46            |
| 19 | ГЕРМЕС ЦЕНТР                 | 158,020                 | 125.00       | 134.00     | 9.00                    | 7.20            |
| 20 | ТҮМЭН ШУВУУТ                 | 392,162                 | 145.00       | 155.00     | 10.00                   | 6.90            |

## Ханшийн бууралттай хувьцаа

/2019.11.30-ны байдлаар/

| №  | Үнэт цаас нэр              | Арилжигдсан<br>/Ширхэг/ | Хаалтын ханш |            | Ханшийн<br>өөрчлөлт (₮) | Өөрчлөлт<br>/%/ |
|----|----------------------------|-------------------------|--------------|------------|-------------------------|-----------------|
|    |                            |                         | 2019-10-31   | 2019-11-30 |                         |                 |
| 1  | СТАНДАРТ ПРОПЕРТИ<br>ГРУПП | 7,300                   | 91.00        | 70.00      | -21.00                  | -23.08          |
| 2  | ДАРХАН НЭХИЙ               | 120                     | 12,900.00    | 10,200.00  | -2,700.00               | -20.93          |
| 3  | БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ        | 82                      | 920.00       | 750.00     | -170.00                 | -18.48          |
| 4  | АВТО ИМПЕКС                | 12                      | 1,850.00     | 1,550.00   | -300.00                 | -16.22          |
| 5  | СОР                        | 10                      | 1,135.00     | 964.75     | -170.25                 | -15.00          |
| 6  | ДӨРВӨН-УУЛ                 | 230                     | 900.00       | 775.00     | -125.00                 | -13.89          |
| 7  | ХЭРЛЭН ХИВС                | 924                     | 58.00        | 50.00      | -8.00                   | -13.79          |
| 8  | АГРОТЕХИМПЕКС              | 165                     | 1,050.00     | 911.00     | -139.00                 | -13.24          |
| 9  | МОНГОЛ НЭХМЭЛ              | 44                      | 2,400.00     | 2,100.00   | -300.00                 | -12.50          |
| 10 | УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР           | 27,658                  | 1,250.00     | 1,101.00   | -149.00                 | -11.92          |
| 11 | ХӨСӨГ ТРЕЙД                | 70                      | 2,186.00     | 1,950.00   | -236.00                 | -10.80          |
| 12 | УВС ЧАЦАРГАНА              | 5                       | 350.00       | 316.00     | -34.00                  | -9.71           |
| 13 | МОНГОЛ КЕРАМИК             | 5                       | 18,040.00    | 16,500.00  | -1,540.00               | -8.54           |
| 14 | АРИГ ГАЛ                   | 246                     | 3,600.00     | 3,300.00   | -300.00                 | -8.33           |
| 15 | ГОВЬ                       | 361,699                 | 269.35       | 252.33     | -17.02                  | -6.32           |



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЭГЖ  
ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЖУРАМ  
БАТЛАМЖЛАГДЛАА**

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дугаар тогтоолоор батлагдсан "Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам"-ыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 537 тоот тушаалаар батламжиллаа. Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээлд олон шинэ үнэт цаас амжилттай гарч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, зах зээл идэвхжихийн хирээр зах зээлийн хөрвөх чадварыг хангах, тогтвортой байдлыг бий болгох асуудал тулгамдаж байгаа бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа билээ. Энэхүү журмын дагуу олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч, мэргэжлийн хөрөнгө оруулагчид болох хөрөнгө оруулалтын сангууд нэгж эрхээ Биржид бүртгүүлж, олон нийтэд нээлттэй арилжих ба хөрөнгө оруулагчид эрсдлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах замаар хөрөнгө оруулалтын оновчтой удирдлагаар хангагдах боломж бий болж байна. Олон улсын практикаас харахад мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлснээр үнэт цаасны үнэ ханш харьцангуй бодит түвшинд, хэлбэлзэл багатайгаар тогтох, арилжааны хэмжээ нэмэгдэхээс гадна жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлдэг байна. Цаашид зохицуулагч болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтран хамтын нээлттэй сангийн нэгж эрхийг бүртгэх, арилжих зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байна.

## Үйл явдал

**"БАЯЛАГ СҮМБЭР" ХК-ИЙН ОНООСОН НЭР  
"ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ" ХК БОЛЖ  
ӨӨРЧЛӨГДЛӨӨ**

СЗХ-ны 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 11/21-5 тоот тогтоолыг үндэслэн "Баялаг сүмбэр" ХК-ийн оноосон нэрийг "Глобал лайф технологи" ХК болгон өөрчиллөө.

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй "Баялаг сүмбэр" ХК-ийн 2019 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар тус компанийн нэрийг өөрчилж, дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/60 тоот тушаал болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн тушаалаар "Баялаг сүмбэр" ХК-ийн оноосон нэрийг "Глобал лайф технологи" ХК болгон өөрчлөлт

**"МАНДАЛ ДААТГАЛ" ХК-ИЙН АРИЛЖААГ ТҮР  
ЗОГСООЛОО**

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар "Мандал даатгал" ХК-ийн хүсэлтийн дагуу тус компанийн хувьцааг 100 хуваах замаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэнтэй холбогдуулан Улсын байцаагчийн 2019 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 79 тоот албан шаардлагаар хувьцаа хуваахтай холбоотой үйл ажиллагаа "ҮЦТХТ" ТӨХХК-д бүрэн хийгдэж дуусах хүртэлх хугацаанд тус үнэт цаасны арилжааг түр зогсоолоо.



## АТАР ӨРГӨӨ ХК-ИЙН ТЕНДЕР АРИЛЖАА ЯВАГДЛАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтад заасан "Компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй этгээд тухайн компанийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг худалдан авахаар сайн дурын үндсэн дээр санал гаргана" гэж заасныг удирдлага болгон "Таван Богд Инвест" ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй "Атар-Өргөө" ХК-ийн 174,136 ширхэг энгийн хувьцааг нэг ширхгийг 60,200 төгрөгөөр худалдан авах санал гаргасан. Хувьцааг худалдан авах тендер саналыг 2019 оны 9 дүгээр сарын 26-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 13:00 цаг хүртэл авсан бөгөөд "Атар-Өргөө" ХК-ийн 44% буюу 76,713 ширхэг хувьцааны 4,618,122,600 төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн байна.

## "АТАР ӨРГӨӨ" ХК-ИЙН ХУВЬЦААГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ДЭЭР АХИН ХУДАЛДАН АВАХ САНАЛ ГАРГАЛАА

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 дахь заалтад заасан "Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр компанийн хувьцааг худалдан авах санал гаргана" гэж заасныг удирдлага болгон "Таван Богд Инвест" ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй "Атар Өргөө" ХК-ийн 97,423 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааны 55.95 хувийг худалдан авах саналыг гаргалаа.

**Санал гаргаж буй этгээд:** "Таван Богд Инвест" ХХК /РД: 6470319, УБД: 9011811139/, Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 17010, Хан Уул дүүрэг, 15-р хороо, Стадион Оргил 1, Чингисийн өргөн чөлөө 6, Хаан банк цамхаг, 10-р давхар, и-мэйл хаяг: [invest@tavanbogd.com](mailto:invest@tavanbogd.com), Утас: 75112222

**Санал болгож буй үнэ:** 60,200 төгрөг  
**Худалдан авах тоо ширхэг:** 97,423 ширхэг  
**Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа:** 2019 оны 11 дүгээр сарын 13  
**Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа:** 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 13:00 цаг

**Хувьцааны худалдан авах төлбөрийг гүйцэтгэх хугацаа:** 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

**Санал гаргагчийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг:** 76,713 ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 44.05%

**Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компани:** "Би Ди Сек ҮЦК" ХК, 75551919-04



## "ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН"-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" (TSX:ERD; MSE:ERDN) нь Монгол улсын баруун хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн өндөр агуулга бүхий илээр олборлох боломжтой Хөндий Алтны Төслийн хараат бус техникийн тайланг танилцууллаа. Энэхүү тайланд Баян Хөндий ордын урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон Баян Хөндийгөөс 16 км зайд орших Алтан Нар ордын шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол орсон байна.

Түүнчлэн, "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК (TSX:ERD; MSE:ERDN) нь Хөндий Алтны Төслийн 2019 оны хоёрдугаар шатны өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулж, 2019 оны 4-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөр эхэлснээ мэдээллээ.

## ЭРДЭНЭ РЕСУРС 3-Р УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ТАЛААР ТАНИЛЦУУЛЛАА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD | MSE:ERDN) нь 2019 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон есөн сарын санхүү, үйл ажиллагааны тайлан болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны оролцоотой санхүүжилтийн талаар шинэ мэдээллийг танилцуулсан байна.

Тайлант хугацаанд тус компани дараах голлох үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- NI 43-101 Техникийн тайлан эерэг үзүүлэлттэй гарав.
- Баян хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2019 оны 8 дугаар сарын 05-ны өдөр авав.
- Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг Sustainability East Asia компаниар хийлгэж байна.
- 9-р сард Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын болон нарийвчилсан өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэв.
- Боловсруулалтын усны нөөцийн өрөмдлөг, судалгааг хийв.
- 2019 оны 4-р улирлын хайгуул ба техникийн хөтөлбөрийг эхлүүлсэн.
- Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны оролцоотой 8 сая канад долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан.

2019 оны 9 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд компанийн нийт алдагдлын хэмжээ 638,379 канад долларт хүрсэн нь 2018 оны мөн үеийн үзүүлэлт болох 743,484 канад доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт боллоо.

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар  
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN